

“Хавсарга хэл шинжлэл” сэтгүүлд тавигдах шаардлага
ISSN 2790-9131

Өгүүллийн ерөнхий шаардлага

Өгүүлэл нь тодорхой судалгаа, туршилтын үр дүнд үндэслэж, шинэ санаа, санал дэвшүүлсэн, хавсралтанд байгаа бүтэц, заавар, журамд нийцүүлж, үг үсгийн алдаагүй бичигдсэн байвал зохино. Илгээж буй өгүүлэл, нийтлэл өмнө нь хэвлэгдээгүй, өөр сэтгүүлд хэвлэгдэхээр хүлээгдээгүй байна. Бусдын бүтээлээс авсан эшлэл ба ашигласан материалыг АРА загварыг баримтлан бичнэ. Ашигласан материалд зөвхөн эшлэл авсан бүтээлийг бичнэ.

Өгүүллийн хэлний шаардлага

Өгүүллийг монгол, англи, орос хэлний аль нэг дээр бичиж болох ба монгол, орос хэл дээр бичсэн өгүүллийн хураангуйг англи хэл дээр, англи хэл дээр бичсэн өгүүллийн хураангуйг монгол хэл дээр хөрвүүлсэн байна. Хураангуй өгүүллийн утга санааг бүрэн илэрхийлсэн 250- 300 үгтэй байна. Өгүүллийн нэрийг англи хэл дээр хавсаргаж ирүүлнэ.

Өгүүлэл, нийтлэлийг хянан магадлах үйл явц

Өгүүллийг 2-3 шүүмжлэгч хянан магадлана. Хэвлэхээр зөвшөөрч, шүүмжийн дагуу зохиогчоос хянан засварласан өгүүлэл “Хавсарга хэл шинжлэл” сэтгүүлийн тухайн жилийн дугаарт хэвлэгдэнэ. Хэвлэгдэхээр зөвшөөрөгдсөн өгүүллийн төлбөрийг зохиогчоос ГХС-ийн дансаар авна.

ЭШ-НИЙ ӨГҮҮЛЭЛ БИЧИХЭД БАРИМТЛАХ ЗААВАР

Үндсэн бичвэрийг А4 хэмжээний 6-12 хүртэл нүүрэнд (б хүртэл хуудас) "Mogul Centurion" фондын 11pt өндөрөөр, мөр хоорондын зайд 1.0, хуудасны зүйн захаас 2,2см, баруун, дээд доод захаас бүр 2.5см зйтай бичнэ. Үүнд ном зүйг оруулж тооцно.

Үндсэн бичвэрийг 2 баганад, өгүүллийн нэр, зохиогчийн нэр, хүснэгт, зураг диаграмм зэргийг нэг багананд мөр голлуулж байрлуулна. Өгүүлэлд тавьж байгаа

шаардлага, зааврыг баримтлаагүй, заасан хэмжээнээс дутуу эсвэл илүү материалыг хүлээж авах боломжгүйг анхаарна уу.

Header, footer командыг ашиглахгүй, хуудсанд дугаар тавихгүй. Зүйлийг шинэ мөрнөөс, эхэлж, мөр хооронд 1sp зйтай, мөрүүд нь баруун, зүүн талдаа зэрэгцэн бичигдэж, догол мөрийн өмнө 6 pt зийт үлдээнэ.

Хүснэгт болон зургийг өгүүлэлд орсон дарааллаар тусад нь дугаарлаж, хүснэгтийн нэрийг баруун дээд талд, зураг дүрслэлийн (График, диаграмм, бүдүүвч, зураг г.м) нэрийг доор нь мөр голлуулж **bold**, *italic* хэлбэрээр 11pt өндөртэй бичнэ.

Жишээ нь:

Хүснэгт 1.1 Геологийн нэр томъёоны орчуулгад хийсэн шинжилгээний дүн

Зураг 3.1 Монгол хэл бичигтэй холбоотой судалгааны дүн

График, диаграмм, зураг, хүснэгт зэргийг зөвхөн **хар цагаан өнгөөр** дагнаж, ялгац сайтай байвал зохино. Scanner ашиглаж оруулсан зургийг 300 dpi-aac багагүй нягтралтай, 'TIF', 'JPEG', 'BMP', 'GIF' өргөтгөлтэй буулгах.

Зураг (График, диаграмм, бүдүүвч г.м)-ийн **мэдээллийн эх үүсвэрийг** нэрийг доор, (Хүснэгтийн мэдээллийн эх үүсвэрийг түүний доор) 12pt зийт авч, *11pt italic* хэлбэрээр бичнэ.

/ЭШӨ БИЧИХ ЗАГВАР/

ӨГҮҮЛЛИЙН НЭР

(14 pt хэмжээтэй **Bold** том үсгээр мөр голлон бичнэ.)

Зохиогчийн овог нэр (үсгийн өндөр 12pt, italic- хэлбэрээр баруун талд зэрэгцүүлж

бичнэ.) Эрдмийн зэрэг, цол, албан тушаал, салбар, тэнхимиийн нэр, судалгааны ажлын салбар, чиглэл, байгууллага, аймаг хот, улс (12pt, баруун талд зэрэгцүүлж

бичнэ.)

Үндсэн сургууль, байгууллагын нэрийг товчлоод, салбар сургууль тэнхим, байгууллагын нэрийг товчлохгүй .

Зохиогчтой харьцах цахим хаяг (үсгийн өндөр 12pt, italic- хэлбэрээр баруун талд зэрэгцүүлжс, доогуур зураасгүй бичнэ.)

Хураангуй (12pt, Bold)

Хураангуйд өгүүллийн гол агуулгыг товч, тодорхой тусгаж, 250-300 үгтэй байна.

(11pt хэмжээтэй, *italic*- хэлбэрээр бичнэ).

Түлхүүр үг (12pt, **Bold)**

(11pt, Өгүүллийн агуулгыг илэрхийлэхүйц 4-5 үгийг нэр үгийн нэрлэхийн тийн ялгалын ганц тоонд бичнэ).

Оршил (12pt, **Bold)**

(11pt, бичвэрийн 5 % орчим, мөр тэнцүүлэх)

Судалгааны арга

Энэ хэсэгт судалгаа нь мэргэжлийн түвшинд хийгдсэн эсэхэд хариулт өгөхүйц байх бөгөөд өгүүллийн бичвэрийн 10- 15%-ийг эзэлж байх.

Үүнд:

- хэрэглэсэн судалгааны арга, аргазүй;
- судалгааны хэрэглэгдэхүүн, туршилт, судалгаа явуулсан хугацаа, түүвэр;
- үр дүнг боловсруулж, задлан шинжилсэн аргазүй, хэрэгсэл; г.м

Үндсэн хэсэгт судалгааны үр дүнг үзүүлнэ.

Судалгааны зорилго-зорилт, (таамаглал) хэрхэн биелж, батлагдсаныг үзүүлнэ. Үндсэн хэсэг өгүүллийн бичвэрийн 50- 60%-ийг эзэлж байх.

Бүлгийн гарчиг (12pt, **Bold мөр голлуулж, том үсгээр)**

Дэд бүлгийн гарчиг (12pt, **Bold**, эхний үсэг нь том, зүүн талдаа зэрэгцэх)

Хэлэлцүүлэг (12pt, **Bold)**

(11pt, бичвэрийн 20- 30% байна)

Энэ хэсэгт өөрийн судалгааны үр дүнг бусад судлаачдын судалгааны үр дүнтэй харьцуулсан дүн шинжилгээ, гарсан үр дүн нь онол практикийн ямар ач холбодолтой, практикт хэрхэн хэрэглэх зэргийг үзүүлнэ. Энэ нь дүгнэлт гаргах гол үндэслэл болно.

Дүгнэлт (12pt, **Bold)**

(11pt, эхний үсэг нь том, мөр зэрэгцүүлж, Regular горимд бичих)

Ашигласан материалын жагсаалт

(12pt, **Bold**, эхний үсэг нь том, зүүн талдаа зэрэгцэх)

(10pt өндөртэй, APA загварыг баримтлан *italic*- хэлбэрээр бичнэ.)

Ашигласан материалыг Монгол ба гадаад хэлээр бичигдсэнийг ялгаж бичнэ. Гадаад хэл дээрх бүтээлийг англи, орос, бусад хэлээр хэвлэгдсэн бүтээл гэж бүлэглэнэ. Гурваас дээш хүмүүсийн хамтын бүтээлд эхний З зохиогчийн нэр, овгийг бичнэ.

Жишээ нь:

I. Монгол хэлээр хэвлэгдсэн бүтээл

1. Бурмаа А., Дармаа Б., Дащцэрэн Л ба бусад, (2005), *2004 оны хүйтний улиралд Монголын хүн амын дунд эргэлтэнд байгаа томоогийн вирусийг тандан судалсан дүн*. “Халдварт судлалын Монголын сэтгүүл”2005.: №3(6): 1-15
2. Төмөрбаатар Н., Балжинням Ш., Гөлгөө А ба бусад (1996), *Материалын эсэргүүцэл*. УБ.: 1996. 295х
3. Алтанцэцэг Ч., Буяндэлгэр Д. (1997), *Монголчуудын өвлийн улиралд голлон өмсдөг хувцасны нэр төрлийн судалгаа* // ТИС-ийн эрдэм шинжилгээний бичиг. УБ.: 1997. N3(29) 41Ц xx.56-65

II. Гадаад хэлээр хэвлэгдсэн бүтээл

1. *Сопротивление материалов* /Под ред. акад. АН УССР. Писаренко Г.С, (1986), с 5-е изд., перераб. и доп. с К.: Вища шк. Головное изд-во, 1986.с 775с.

Эшлэлийг “APA” загварыг баримтлан бичнэ (Тайлбар харах).

Зохиогчийн тухай (12pt, **Bold**, эхний үсэг нь том, зүүн талдаа зэрэгцэх)

(10pt өндөртэй, боловсролын зэрэг, эрдмийн цол, судалгааны ажлын чиглэл)

Талархал (12pt, **Bold**, эхний үсэг нь том, зүүн талдаа зэрэгцэх)

(10pt өндөртэй, зохиогчоор оруулах боломжгүй боловч судалгаа хийх, боловсруулахад хувь нэмэр оруулсан байгууллага, хүмүүст хандсан талархал.)

ЭШ-НИЙ БҮТЭЭЛД ЭШЛЭЛ АВАХ “APA” ЗАГВАРЫН ТАНИЛЦУУЛГА

APA Citation Style (American Psychological Association): Энэ загварыг Америкийн сэтгэл судлалын нийгэмлэгээс гаргадаг бөгөөд нийгэм, хүмүүнлэгийн шинжлэх ухаан болоод эдийн засаг, бизнесийн салбарын судалгааны бүтээлүүдэд эшлэл хийхэд түгээмэл ашиглагддаг загвар юм. Уг загварын онцлог нь “зохиогч-on cap” гэсэн мэдээллийг илүү анхаарч үздэг (Writer Resources, 2013).

APA загвараар эшлэл авахад 1. Эх бичвэр дотор эшлэл авах

2. Эшлэл авсан бүтээлийн жагсаалтыг эх бичвэрийн дараа бичдэг.

APA загварын дагуу эх бичвэрт эшлэл авахад зохиогчийн эх бүтээлээс авсан үндсэн санааг илэрхийлсэн өгүүлбэрийн ард **зохиогчийн овог, бүтээлийн хэвлэгдсэн он, хуудсын дугаарыг** бичнэ. Энэ загвараар бичвэрт эшлэл авахад үндсэн эх 40-өөс дээшгүй үтгэй тохиолдолд 1) шууд эшлэл авдаг (Writer Resources, 2013). Тухайлбал;

“Улсаас хэлийг төлөвлөхдөө эхлээд үндэстний хэлийг сонгож дараа нь үндэстний цөөнхийн хэлд хэрхэн хандахаа шийдвэрлэнэ” Зэгиймаа.Ч, 2009, x-45. Эсвэл

Доктор, профессор Ч.Зэгиймаа (2007) - гийн тэмдэглэсэнээр “Улсаас хэлийг төлөвлөхдөө эхлээд үндэстний хэлийг сонгож дараа нь үндэстний цөөнхийн хэлд хэрхэн хандахаа шийдвэрлэнэ” (х-45) хэмээн судлаачид үзэж байна.

Шууд эшлэл гэдэг нь ашиглаж байгаа эх сурвалжаас тодорхой хэсгийг хашилтын тэмдэгт ашиглан үг үсэг өөрчлөхгүйгээр шууд судалгааны ажилдаа авч хэрэглэхийг хэлнэ. (Research and Citation).

Хэрвээ эшлэл авах эхийн хэмжээ 40 –өөс дээш үтгэй бол 2) *тоймолж бичих*; болон 3) *найруулж бичих* гэсэн хэлбэрээр судлаачдын оюуны бүтээлээс эшлэж авдаг. Тухайлбал;

Ашиглаж буй номонд: *Интеграци* гэдэг үг нь “**Integration**” гэсэн англи үгнээс гаралтай бөгөөд аливаа “**интеграци**” гэдэг тухайн үйл ажиллагааны нэгдмэл цогц, залгамж чанарын хоршил гэсэн ойлголт бөгөөд “**боловсролын интеграци**” нь бие хүний хөгжлийн тухайн шатны хэрэгцээг хангахад чиглэсэн боловсрол тасралтгүй олгох үе шат, түүний бүх түвшингийн нэгдмэл залгамж чанарын хоршил юм (Ө.Ариунтуяа, 2009).

Тоймлохдоо: Судлаач Ө. Ариунтуяа (2009) өөрийн судалгааны ажилдаа интеграци гэдэг ухагдахууны гарал үүсэл болон тодорхойлолтыг өгснөөр боловсролын интеграцийг бие хүний боловсрол эзэмших үе шатууд, мөн боловсролын түвшин бурийн хоорондын нэгдмэл залгамж чанарын хоршил юм хэмээн тодорхойлсон байна.

Тоймлох гэдэг нь судлаач эх сурвалжийг сайн уншиж ойлгосны үндсэн дээр тухайн эхийн **гол санааг** тэр эхэд байгаа зарим үгс, нэр томьёог ашиглан судалгааны ажлынхаа агуулгыг баяжуулахыг хэлнэ. Тоймлон бичих аргаар бусдын санааг ашиглах нь ихэвчлэн үндсэн эх сурвалжаас бага хэмжээтэй байдаг (Research and Citation).

Ашиглаж буй номонд: *Боловсролыг хүмүүст мэдлэг, чадвар, дадал системтэй эзэмшиүүлэх үйл явц; бие хүнийг амьдралд бэлтгэх чухал нөхцөл; хүмүүсийг урлаг соёлтой ойртуулах, түүнийг эзэмших гол хэрэгсэл; тасралтгүй төрөлжин арвижсах байнгын үйл ажиллагаа гэх мэтээр үзэж судалж ирснийг нэгтгээж бие хүний хөгжил, төлөвшийл болон зан үйтэй холбож боловсролын олон талт үйл явцад авч үзэх шаардлагатай юм* (Л.Жамц, 2009).

Найруулан бичихдээ: Доктор, профессор Л.Жамц (2009) боловсрол гэдэг ухагдахууныг тайлбарлахдаа хүн амьдралынхаа явцад олон зүйлийг таньж мэдэн амьдралынхаа туришид хэвшүүлэн зуриш болгож улмаар нийгмийн харилцаанд оролцож аливааг үзэх үзэл бодол төлөвшииж, хөгжих нийгмийн олон талт тасралтгүй үйл явцыг боловсрол гэж тодорхойлсон байна.

Найруулан бичих гэдэг нь судлаач ашиглаж буй эх зохиолд өгсөн мэдээллийн утгыг өөрийн ойлгосон байдлаар тайлбарлаж бүтээлдээ ашиглахыг хэлэх бөгөөд эхэд дурдсан нэр томьёоноос тун цөөхнийг авч хэрэглэнэ (Shinebayar.N, 2014).

АРА загварын дагуу ашигласан бүтээлийн жагсаалтад эшлэл авсан бүтээлээ тусгахдаа **зохиогчийн нэрийг бус овгийг** үсгийн дараалалаар мөн бүтээлийн хэвлэгдсэн оны дараалалаар бичдэг.

 **I** үсэг зохиогчийн овог бөгөөд үсгийн дарааллаар N-ийн өмнө байрлаж байна

1. Hexham, I. (2005). The Plague of Plagiarism: Academic Plagiarism Defined. *Irving Hexham's Page*, 1. Retrieved from Academic Plagiarism: <http://people.ucalgary.ca/~hexham/>
2. Shinebayar.N. (2014, 11 20). Retrieved from Slideshare.net: <http://www.slideshare.net/shinebayarshineeeee/ss-41811497>